

“УЛААНБААТАР ГУРИЛ” ХХК

**“БОСОО ТЕХНОЛОГИТ
ГУРИЛЫН ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

ОРШИЛ	1
НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1. Улаанбаатар гурил ХХК-ийн үйл ажиллагаа	2
1.2. Төслийн дэд бүтэц	3
1.3. Үйлдвэрийн тоног төхөөрөмж.....	4
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	5
2.1. Төсөл хэрэгжих талбай орчмын физик, газар зүй, ландшафт.....	5
2.2. Цаг уур, уур амьсгал.....	5
2.3. Агаарын чанар	5
2.4. Геоморфологи.....	7
2.5. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал.....	8
2.6. Ургамлын нөмрөгийн төлөв байдал.....	8
2.7. Амьтны аймаг.....	8
2.8. Гадаргын ус.....	8
ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ	9
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	9
3.4. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	10
3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах өргөн хэмжээний төлөвлөгөө.....	11
3.6. Хог хаягдлын төлөвлөгөө	11
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	13
4.2. Ажиллагсдын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны төлөвлөгөө	15
4.3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	16
4.4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	16
4.5. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн	17
4.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
4.6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	17
4.7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
4.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	18
4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	19
4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага	19
4.11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах	20

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Төслийн байршил	3
Зураг 2.	Төслийн өнөөгийн байдал	4
Зураг 3.	Буудай хадгалах силос	5
Зураг 4.	Хүхэрлэг хий	6
Зураг 5.	Азотын давхар исэл	6
Зураг 6.	Том болон нарийн ширхэглэгт тоосонцор	7

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Төслийн талбайн солбилцол	3
Хүснэгт 2.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13
Хүснэгт 3.	Ажиллагсдын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны төлөвлөгөө	15
Хүснэгт 4.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	16
Хүснэгт 5.	Тарималжуулах ажилд зарцуулах зардлын хэмжээ	16
Хүснэгт 6.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	18
Хүснэгт 7.	Орчны хяналт шинжилгээний хөлөтбөр	19
Хүснэгт 8.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	19
Хүснэгт 9.	Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө	20
Хүснэгт 10.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн	20

ОРШИЛ

“Улаанбаатар гурил” ХХК-ийн “Босоо технологит гурилын үйлдвэр”-ийн /цаашид “Төсөл” гэх/ зориулалттай төслийн газар нь Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт 45068м² талбайг хамран оршиж байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

“Улаанбаатар гурил” ХХК-ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд болон төслийн үйл ажиллагаа, төсөл хэрэгжиж буй талбайн төлөв байдал болон төслийн талбай орчимд хийгдсэн өмнөх шинжилгээний дүнг ашиглаж, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайдын 2019-10-29-ны А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр Төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь зөвхөн төслийн ашиглалтын үйл ажиллагаанд үндэслэн хийгдсэн бөгөөд холбогдох бусад бүхий л ажиллагааг байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй нягт уялдуулан ажиллах нь зайлшгүй шаардлагатай юм.

НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр:	“Босоо технологит гурилын үйлдвэр”
Төсөл хэрэгжүүлэгч:	“Улаанбаатар гурил” ХХК
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, БГД-25-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Таван Богд Группийн байр
Төслийн байршил, хаяг:	Дархан-Уул аймаг, Дархан сум 13-р багийн нутагт байрлана.
Нэгж талбарын дугаар:	4505100134
Нийт талбайн хэмжээ:	45068м ²
Газар ашиглах зориулалт:	Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад
Газар ашиглах, эзэмших шийдвэр:	Дархан-Уул аймгийн Дархан сумын Засаг даргын 2015 оны А/206 дугаар захирамж
Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар:	000012001
Регистерийн дугаар:	2624036
Дэд бүтэц:	Дулаан хангамж: Дулааны төвлөрсөн эх үүсвэрт холбогдсон. Усан хангамж: Төвийн төвлөрсөн эх үүсвэрт холбогдсон. Хэрэглээнээс гарах бохир ус: Бохир ус татан зайлуулах нэгдсэн системд холбогдсон. Цахилгаан хангамжийн эх үүсвэр: Цахилгаан хангамжийн эх үүсвэрт холбогдсон.

“Улаанбаатар гурил” ХХК нь 2012 онд Дархан-Уул аймгийн үйлдвэрийн Турк улсын Alarala компанийн тоног төхөөрөмжөөс бүрдсэн хоногт 300 тонн үр тариа тээрэмдэх хүчин чадалтай бүрэн автоматажсан, компьютер удирдлагын системтэй, босоо технологитой 5 давхар үйлдвэр болон буудай хадгалах силос, буудай хатаах иж бүрэн тоног төхөөрөмж, гурил хадгалах агуулах, бусад бараа материал хадгалах агуулах, оффис зэрэг гурилын цогцолбор үйлдвэртэй.

Улаанбаатар гурилын үйлдвэр нь зарим уламжлалт гурилын үйлдвэрүүдтэй харьцуулахад цэвэр усыг 12 дахин бага зарцуулдаг, эрчим хүчийг 25% бага хэрэглэдэг байгаль орчинд ээлтэй, орчин үеийн цогцолбор гурилын үйлдвэр юм.

1.1. Улаанбаатар гурил ХХК-ийн үйл ажиллагаа

Төслийн зорилго: “Улаанбаатар гурил” ХХК нь Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг өөрийн үйлдвэрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд хүргэх зорилгоор түр хугацаанд хадгалж, борлуулагч руу түгээдэг. Тус компани нь гурилын үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаа явуулж, байгаль орчиндоо сөрөг нөлөөлөлгүй шинэ техник, технологийг ашиглаж хэрэглэгчдэдээ эрүүл, аюулгүй хүнс хүргэх нь төслийн гол зорилго болно.

Төслийн байршил

Төслийн талбай нь 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/206 тоот захирамжтай, Дархан-Уул аймгийн Дархан сумын 13-р багийн нутаг, үйлдвэрийн бүсэд байрзүйн М-48-92 хавтгайд хараа голын сав газарт хамааран 45068м² талбайг хамран байрлаж байна.



Зураг 1. Төслийн байршил

Хүснэгт 1. Төслийн талбайн солбилцол

№	X	Y
1	105 57 17.88	49 25 32.32
2	105 57 13.72	49 25 30.68
3	105 57 11.4	49 25 32.99
4	105 57 27.21	49 25 39.12
5	105 57 27.03	49 25 39.28
6	105 57 30.53	49 25 40.58
7	105 57 36.06	49 25 42.83
8	105 57 36.38	49 25 41.59
9	105 57 35.72	49 25 39.87
10	105 57 32.49	49 25 38.47
11	105 57 29.01	49 25 36.96
12	105 57 24.02	49 25 34.78
13	105 57 22.25	49 25 34.13
14	105 57 20.36	49 25 33.29
15	105 57 19.03	49 25 32.75

1.2. Төслийн дэд бүтэц

Гурилын үндсэн түүхий эд болох улаан буудайг хүлээн авах, цэвэрлэх талбай, агуулахууд хангалттай. Нийт хашааны хэмжээ 4.51 га. Үүнээс:

- Үйлдвэрийн барилга 4905.8 мкв
- Бэлэн бүтээгдэхүүний агуулахууд 4354 мкв
- Улаан буудайн силос 4144 мкв
- Үйлчилгээний, оффисын барилга 846 мкв

Үндсэн барилга байгууламж нь гурилын үйлдвэр, улаан буудайн агуулах, бэлэн бүтээгдэхүүний агуулах гэсэн бүрэлдэхүүнүүдтэй. Үйлдвэрийн барилга 5 давхар, тоосгон хийцтэй.



Зураг 2. Төслийн өнөөгийн байдал

1.3. Үйлдвэрийн тоног төхөөрөмж

2012 онд Турк улсын Alarala компанийн тоног төхөөрөмжөөс бүрдсэн хоногт 300 тонн үр тариа тээрэмдэж хүчин чадалтай бүрэн автоматажсан, компьютер удирдлагын системтэй, босоо технологитой 5 давхар үйлдвэр болон буудай хадгалах силос, буудай хатаах иж бүрэн тоног төхөөрөмж, гурил хадгалах агуулах, бусад бараа материал хадгалах агуулах, оффис зэрэг гурилын цогцолбор үйлдвэрийг барьж байгуулснаараа онцлог давуу талтай.



Зураг 3. Буудай хадгалах силос

2020 оны 12 дугаар сард Англи улсын “BUHLER” брэндийн буудайнаас өнгөөр ялгаатай тарианы ба хог хольцыг ялгах зориулалттай SORTEX A маркийн өнгөөр ялгагч машиныг суурилуулан ашиглалтад оруулсан. 2020 оны 7 дугаар сард бэлэн бүтээгдэхүүнийг хортон шавж мөн нүдэнд үл үзэгдэх өндөг авгалдайгаас урьдчилан сэргийлэх зорилгоор савлахын өмнөх технологийн процесст Турк улсын “ALAPALA” брэндийн хяналтын DVDU минутад 3000-ийн эргэлтийн хүчин чадалтай төхөөрөмжийг вакуум шугамд суурилуулсан.

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Төсөл хэрэгжих талбай орчмын физик, газар зүй, ландшафт

Дархан-Уул аймаг нь хуучнаар Дархан хотын нутаг дэвсгэр дээр 1994 онд байгуулагдсан. Нийслэл Улаанбаатарын дараа ордог хоёрдох том хот бөгөөд 223 км зайтай. Нутаг дэвсгэрийн хэмжээ 327.5 мян.га. Засаг захиргааны нэгжийн хувьд 4 сум, 24 багтай. Сэлэнгэ, Төв аймгийн хилтэй залгаа оршдог. Дархан-Уул аймгийн 7 гайхамшгаар Тахилгат их Дархан уул, Дурлалын мод, Шарын голын зосон зураг, Буурал уулын булш, Дүрс нарс, Лам Дондовын рашаан, Хүйтний голын хадны бичээс зэрэг газрууд тодорчээ.


2.2. Цаг уур, уур амьсгал

Дархан-Уул аймаг нь Монгол орны хойд, Сэлэнгэ аймгийн төв хэсэгт, Хэнтийн нурууны салбар уулсын хоорондох намхан гүвээ толгод, Хараа голын хөндийд далайн түвшнээс дээш 705м өндөрт, уртрагийн 105°56', өргөргийн 49°29' оршино. Байгалийн эрс тэрс уур амьсгалтай, жилийн 4 улирлын ялгаа ихтэй, агаарын температурын хэлбэлзэл их, хур тунадасны хэмжээ, чийг багатай цаг агаарын нөхцөлтэй. Тус аймаг нь уур амьсгалын мужлалын хувьд ширүүвтэр өвөлтэй, дулаан зунтай, чийгээр дутмаг мужид багтдаг.

2.3. Агаарын чанар


Дархан сумын агаарын чанар тодорхойлсон үзүүлэлтүүдээс түгээмэл бохирдуулагч хүхэрлэг хий /SO₂/, азотын давхар исэл /NO₂/-ийн агууламж болон том ширхэглэгт тоосонцор гадаад орчны агаарын чанарын MNS 4585:2016 стандарттай харьцуулахад нэг удаагийн сорьцын

хүлцэх агууламжаас давсан тохиолдоогүй. Агаарын чанарын хяналтын цэгүүдэд тодорхойлсон үзүүлэлтүүдийг доорх зурагт үзүүлэв.




Зураг 4. Хүхэрлэг хий

Дархан суманд агаар дахь хүхэрлэг хийн /SO₂/ дундаж агууламж 5 мкг/м³, Шарын гол суманд дундаж агууламж 17 мкг/м³, агаарын чанарын MNS4585:2016 стандартын 1 удаагийн сорьцын хүлцэх агууламж 450 мкг/м³-аас давж бохирдсон тохиолдолгүй. Дархан сумын хамгийн их агууламж 7 мкг/м³, Шарын гол сумын хамгийн их агууламж 19 мкг/м³ байна.



Зураг 5. Азотын давхар исэл

Дархан суманд агаар дахь азотын давхар исэл /NO₂/ дундаж агууламж 28 мкг/м³, Шарын гол суманд дундаж агууламж 38 мкг/м³, агаарын чанарын MNS4585:2016 стандартын 1 удаагийн сорьцын хүлцэх агууламж 200 мкг/м³-аас давж бохирдсон тохиолдолгүй. Дархан сумын хамгийн их агууламж 39 мкг/м³, Шарын гол сумын хамгийн их агууламж 42 мкг/м³ байна.



Зураг 6. Том болон нарийн ширхэглэгт тоосонцор

Хуучин Дархан орчимд PM₁₀ тоосонцрын хэмжилтийг 24 цагийн хэмжилтийн дүнгээр 49-65 мкг/м³, дундаж агууламж нь 57 мкг/м³ бөгөөд агаарын чанарын MNS4585:2016 стандартын хүлцэх агууламжаас давсан бохирдолгүй. Хуучин Дархан орчимд PM_{2.5} тоосонцрын хэмжилтийг 24 цагийн хэмжилтийн дүнгээр 42-85 мкг/м³, дундаж агууламж нь 61 мкг/м³ бөгөөд агаарын чанарын MNS4585:2016 стандартын 24 цагийн хүлцэх агууламжаас 1.3-1.7 дахин давж бохирдсон.

2.4. Геоморфологи

Олон төрлийн хэв шинжийг ялгаж болох бөгөөд ихэвчлэн өндөр ба нам уулс, ухаа гүвээт толгод, голын нам, өндөр татам, хуримтлалын өндөр дэнж аллюви-делюви, делюви-пролювийн хурдас зонхилно. Төсөл хэрэгжих талбай нь геоморфологийн хувьд Сибирийн геоморфологийн их мужийн болон төв Азийн их мужийн завсар буюу Орхон Сэлэнгийн дэд мужид багтах агаад уулс хоорондох хотгор хотос буюу ховдолд байрлана. Гадаргын эгц налуу дунджаар 3-6.0, гадаргын шигүү (голын голдирол хоорондын болон нам дор газрын хоорондох дундаж зай) 5000 метрээс доош, хэрчигдлийн гүн 400-600м хүрдэг аж.

“Улаанбаатар гурил” ХХК-ийн үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар зориулалтаар эзэмшдэг 45068 м² газар нь ДТД 707-731 метрийн өндөрт өргөгдсөн газрын гадаргын хэвгий буюу налуу нь (2-4 градус) тэгш гадаргууд байрлаж байна.

2.5. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэр манай орны нутгийн хойп хэсэгт орших бөгөөд Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн өндрийн бүсшилийн Хэнтийн мужийн Хэнтийн захын 39-р тойрогт хамрагдана. Хэнтийн нурууны хэсгийн уулархаг нутгаар шинэс, хуш, хус, нарсан ой, бүхий газраар голлон тогтворжсон байдаг. Хөрсөн бүрхэвч зузаан биш, хайрга чулуун давхарга дээр оршдог. Үетэн-нугын алаг өвст бүлгэмдэл бүхий ургамлан нөмрөгтэй, хад чулуу элбэгтэй байх тул ялзмаг хуримтлалын давхарга харилцан адилгүй байдаг хэдий ч хөрсний үржил шимийн түвшин өндөртэй байна. Хар хүрэн хөрс бүхий газар бараг нэлэнхүйдээ газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглагддаг.

2.6. Ургамлын нөмрөгийн төлөв байдал

Аймгийн хэмжээгээр ойн сангийн нийт талбайн 96.4% буюу 76135 га-г ойн талбай, 3.6% буюу 2877 га-г ойн бус талбай эзэлдэг бөгөөд ойн сангийн 72.8 хувийг хус, 23.7 хувийг нарс эзэлдэг. Монгол улсын улаан ном (2013)-д нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай нэн ховор, ховор 135 зүйлийн дээд ургамлыг оруулсан байна. Монголын ургамлын улаан дансанд (2012) нийт 110 зүйл орсноос 16 зүйл нь нэн ховор, 39 зүйл нь устаж болзошгүй, 55 зүйл нь эмзэг гэсэн ангилалд багтжээ. Энэхүү судалгаанд багтсан нэн ховор, ховор 32 зүйл ургамал тэмдэглэжээ. Хараа, Шарын голын хөндийгөөр хөрсний бүтэц, үржил шимийн хувьд газар тариалан, малын бэлчээрт тохиромжтой.

2.7. Амьтны аймаг

Аймгийн нутгийн 400 орчим зүйлийн, 4 зүйлийн гүрвэл, хоёр нутагтан, 50 гаруй зүйлийн загас, 5 зүйлийн туурайтан, 30 гаруй зүйлийн мэрэгчид, 10 гаруй зүйлийн махан идэштэн, 2 зүйлийн гар далавчтан 12 зүйлийн нялцгай биетэн, 12000 зүйлийн шавж багтдаг.

2.8. Гадаргын ус

Төслийн талбай орчим нь гадаргын усны ангиллаар Хараа-Шараа голын сав газарт хамаарах бөгөөд Хараа голын эрэг дээр Дархан аймаг байрладаг. Дархан-Уул аймгийн нутгаар Хэнтийн нуруунаас эх авч цутгадаг. Хараа, Зулзага, Шарын гол, Орхон, Ерөө, Хүйтний, Хавчуун зэрэг голууд урсдаг.

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Агаар

Агаарын чанарын гадаад орчны түгээмэл тархацтай бохирдуулах бодисыг хянахдаа “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2025 стандартаар, Гадаад орчны агаарын бохирдуулах бодисыг хянахдаа ”Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008 стандарт”-аар, Ажлын байрны орын бичил цаг уурын эрүүл ахуйн шаардлага, агаар дахь хорт бодисыг хянахдаа “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй, Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS4990:2015 стандартаар тодорхойлж төсөл хэрэгжүүлэгч эдгээрээс давах бохирдуулагч гаргахгүй байхад үндэслэгдэнэ.

- Төслийн нийт талбайн хэмжээнд талбайн тохижилтыг хийх, халцарч зулгарсан хөрсөн гадаргуугийн хэмжээг багасгаж ногоон бүс байгуулах.
- Авто тээврийн хэрэгслийг жил бүр үзлэгт хамруулж, агаарын бохирдлын төлбөрийг төлөх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх.
- Цаг агаарын аюултай болон онц аюултай үед үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоох.
- Ахуйн болон бүх төрлийн хог хаягдлыг цаг тухай бүрд нь тээвэрлэж зайлуулж байх. Үйлдвэрийн талбайд хатуу хог хаягдлыг шатаахгүй байх, хаяхгүй байх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх.

Хөрсөн бүрхэвч

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Үйлдвэрийн үйл ажиллагаанд өртөж эвдэрсэн хөрсөн бүрхэвчийг засаж тэгшлэх, олон наст ургамлын үр тарих (зүлэг), мод, сөөг тарих зэргээр ургамалжуулах, ногоон байгууламж байгуулах.
- Төслийн ерөнхий төлөвлөлтийг зураг төслийн дагуу гүйцэтгэх (тээврийн хэрэгслийн зогсоол, явган хүний замыг зориулалтын дагуу тохижуулах)
- Автомашины зогсоолыг талбайг тэгшлэн шатах, тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлэх, тэмдэгжүүлэх, засвар үйлчилгээний ажлыг тогтмол хийж байх, төсөл хэрэгжих талбай, түүний орчинд машин техникийн шатах тослох материал асгарвал тухай бүрд нь цэвэрлэж, хөрсний бохирдлоос сэргийлэх.
- Үйлдвэрийн талбайд болон ойр орчимд хатуу ба шингэн хог хаягдал хаяхгүй байх /хатуу, шингэн хог хаягдлыг тухай бүрд нь цэвэрлэж зөвшөөрөгдсөн газарт хаях, зохих шаардлагын дагуу ариутгах/
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасны дагуу тогтоосон цэгүүдээс хөрсний сорьц дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэх.
- Ажилчдад ил задгай хог хаягдал хаях, хөрсийг бохирдуулахгүй байх талаар анхааруулга, санамж зөвлөгөөг тогтмол өгч байх. Хогийн савуудыг олноор байрлуулах хэрэгтэй.
- Машин техник зорчих замыг тодорхой болгож онцын шаардлагагүй тохиолдолд олон салаа зам гаргаж хөрс талхлагдахаас урьдчилан сэргийлэх.

Гадаргын болон гүний ус

Үйлдвэрийн цэвэр болон бохир усны шугам сүлжээг байнга шалгаж байх.

Ургамлан бүрхэвч

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан бүрхэвчид учруулах сөрөг нөлөөлөл харьцангуй бага боловч, төслийн хүрээнд ашиглалтгүй талбайг хамгаалах нь чухал юм. Тиймээс төслийн талбайн тохижилтод дараах зүйлүүдийг хийх шаардлагатай. Үүнд:

- Төслийн үйл ажиллагааны явцад эвдэрсэн газрыг засаж тохижуулах, ногоон байгууламж байгуулах, мод бут тарих.
- Түлш, шатах тослох материалаар ургамлан нөмрөгийг бохирдуулахаас сэргийлэх.
- Төслийн эдэлбэр газраас бусад талбайн ургамлыг хамгаалахын тулд машин техникийг тогтоосон маршрутын дагуу явуулах, олон салаа зам гаргахгүй байх, замыг тэмдэгжүүлэх.
- Ургамлан нөмрөг тоосонд дарагдахаас сэргийлж зам, талбайг усалж байх.
- Төсөл хэрэгжүүлэх орчны ургамлын төрөл зүйл, тархалт, өсөлт хөгжилтөд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх, ургамлан нөмрөгийн байдалд байнгын ажиглалт, хяналт тавьж ажиллах.

Амьтны аймаг

Суурьшлын бүс бий болсноор шувуудын зүйлийн бүрдэл өөрчлөгдөх, хүмүүнсэг амьтад, шувуудын зүйлийн бүрдэл, тоо толгой нэмэгддэг. Хээрийн бор шувуу, тагтаа, хараацай, шаазгай, хэрээ, элээ, улаан хошуут, гэрийн хулгана гэх мэт хүний суурьшилтын бүсэд олноор засан зохицож амьдардаг амьтдын тоо толгой нэмэгдэж, орон байрны паразит амьтад үүрлэх, өвчин үүсэх, эргээд үйлдвэрийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсдэг.

Ил хаясан хог хаягдал, бохир усны тогтоол зэрэг нь шувууд болон бусад амьтад цугларах нөхцөл болдог учир цаг тухайд нь цэвэрлэж, хог хаягдлын менежментийн дагуу ажиллах шаардлагатай.

Нийгэм эдийн засаг

1. Орон нутгийн удирдлага болон ард иргэдийн дунд төсөлтэй холбоотой хийж гүйцэтгэсэн ажил болон ирээдүйн ажлын төлөвлөгөөгөө ил тод нээлттэй байлгах.
2. Ажилчдад ажлын байранд тавигдах хэв журам, сахилга батын дэглэмтэй байх.
3. Төслийн гүйцэтгэлийг хянаж, шалгах ба эдийн засгийн алдагдал болон бусад мэдээллийг оролцогч талууд болон орон нутгийн удирдлагуудад мэдээлж байх.
4. НӨАТ, НДШ, ХАОАТ, ашгийн татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар, тусгай зөвшөөрлийн төлбөр гэх мэтээр улсад татварууд төлнө. Хууль тогтоомжийн дагуу төлбөр хураамжийг цаг тухайд нь хийж байх.

3.4. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ

- Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг ажилчдад анхааруулах, гал унтраах багаж хэрэгслийг бэлэн байлгах, нэгэнт гарсан тохиолдолд холбогдох байгууллагад яаралтай мэдэгдэж, гал түймрийг богино хугацаанд унтраах аргыг ажилтнуудад эзэмшүүлэх.

- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үйл ажиллагааныхаа мөрийн хөтөлбөрт болгон зүйл бүрийг маш сайн биелүүлж ажиллах.
- Үйлдвэрээс гарах хог хаягдлыг Монгол улсын Засгийн газрын 116-р тушаалын дагуу ангилан ялгаж тусгай саванд хийж түр хадгалаад мэргэжлийн байгууллагаар зайлуулж байх.
- Зөвшөөрөлтэй газар нутгийнхаа хүрээнд хүчин чадалдаа тохируулан үйл ажиллагаа явуулах орчны тохижилтын ажлыг хийхдээ байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх, талаас нь анхаарч цахилгааны хэрэгцээг хангахад, ялангуяа гэрэлтүүлэг, дулаалга, халуун ус зэргийг аль болохоор зөв зохистой ашиглах нь зүйтэй.
- Эрчим хүч хэмнэх тоног төхөөрөмж суурилуулах.
- Төслийн хүрээнд байгаль орчны мэргэжилтэн авч ажиллуулах эсвэл нэг удирдах ажилтанд энэ үүргийг давхар ноогдуулна.
- Байгаль орчин хамгаалах календарчилсан төлөвлөгөө боловсруулах, түүний хэрэгжилтийг хянах, хөрөнгө зарцуулалтын хуваарь гаргах.
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан агаар, хөрс, ус нөхөн сэргээлтийн мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, энэ нь нь гүйцэтгэгч компанийг байгаль орчин бохирдуулсны төлбөрөөс зайлсхийх боломжийг олгоно.
- Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайланг хийж хэрэгжүүлэхдээ БОАЖС-ын 2016 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтална.
- Төслийн эзэмшлийн газар болон ойр орчимд ногоон ургамал тарих, цэцгийн мандал байгуулах, мод суулгаж, суулгасан модоо тогтмол арчлан ургуулах, ургахгүй байвал дахин нөхөн суулгах ажлыг зохион байгуулж байх.

Дээрх бүгдийг практикт хэрэгжүүлснээр “Байгаль орчинд ээлтэй эдийн засгийн бодлого нийгмийн хөгжил”-ийг бий болгоно.

3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах өргөн хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд ямар нэг түүх, соёлын өв, дурсгал зүйлс байхгүй тул сөрөг нөлөө тодорхойлогдохгүй.

3.6. Хог хаягдлын төлөвлөгөө

Хог хаягдлын тухай 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн /шинэчилсэн найруулга/ хууль нь 8 бүлэг 43 зүйлээс тогтох ба тус хуулийн 1-р зүйлд заасан хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Үйлдвэрийн хатуу хог хаягдал

Үйлдвэрлэлийн явцад чулуу, элс, шороо зэрэг эрдэст хаягдал багахан хэмжээгээр гарах бөгөөд энэ нь байгаль орчинд ямар нэгэн хор нөлөө байхгүй юм. Үйлдвэрлэлийн явцад гарах

хуурай хог хаягдал болон ахуйн хог хаягдлыг Дархан сумын Засаг даргын тамгын газартай гэрээлэн төвлөрсөн хогийн цэг рүү зөөж зайлуулдаг. Үйлдвэрийн дамжлагаас үүсэх хатуу хог хаягдал нь улаан буудай хэрэггүй хог, ургамал, үр чулуу зэрэг байна.

Хийн хаягдал

Үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааны явцад агаарт ямар нэгэн хий гарахгүй. Үйлдвэрийн түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн тээвэрлэх зэрэг, хэрэглэгдэх автомашинаас гарах хийн хаягдал нь агаарын бохирдлын тухайлсан эх үүсвэрт орж байна.

Ахуйн хог хаягдал

Үйлдвэрт ажиллагсдын ахуйн хуурай хог хаягдал гарна. Хуурай хог хаягдлын тусгай талбай, бий болгож, тагтай битүүмжлэл сайн байлгах шаардлагатай бөгөөд хогийг ангилан ялгах хэрэгтэй. Тухайлбал үйлдвэрийн ажиллагсдын ахуйн болон цайны газрын хоол хүнсий зүйлийн үлдэгдэл, баглаа боодол зэрэг хатуу хог хаягдал ба нэг хүнээс хоногт дунджаар 0.3кг хог хаягдал гарна гэвэл үйлдвэрт ажиллах 270 хүнээс хоногт бүгд 81кг буюу сард 1782кг, жилд 21.38тн хатуу хог гарахаар байна. иймд хатуу хог хаягдлыг өөрийн хогийн цэгийн тусгайлан бэлдсэн битүү саванд төвлөрүүлж байгаад сар тутам хогийн төвлөрсөн цэгт хаяж байх нь зүйтэй.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа Босоо технологит гурилын үйлдвэр үйл ажиллагааны явцад байгаль орчинд ямар сөрөг нөлөөлөл үзүүлж байгааг тодорхойлсны үндсэн дээр тус төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор хүрээлэн буй орчинд, хүний эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөлөл, түүнээс сэргийлэх арга зам, анхаарвал зохих асуудлын талаар нарийвчлан төлөвлөлөө. Үүнд: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр заавал авч хэрэгжүүлж байх арга хэмжээ, агаар, хөрс, ус зэрэг болох байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд тавих талаар хяналт шинжилгээний хөтөлбөрт тодорхой тусгаж оруулсан болно.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгах шаардлагатай байдаг.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Энэ хэсэгт байгаль орчны судалгааны явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зардал зэргийг оруулсан болно.

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	Гурил хивэг савлах үед агаарт тоосонцор үүсэх, хуримтлагдах	Тоосжилтыг бага байлгахын тулд агааржуулалт, чийгтэй цэвэрлэгээ хийх	Гурилын агуулах, гурил савлах хэсэг, гурилын ачих хэсэг	Удаа	ҮА-ны зардлаар			Төслийн үйл ажиллагааны явцад тогтмол хэрэгжүүлэх	Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 сарын 24-ны өдрийн А/406 дугаар тушаалын 3 дугаар хавсралт “Хүнсний үйлдвэрийн эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм”
2	Гурил тээрэмдэх үед шуугиан, доргио, чичиргээ үүсэх	Дуу шуугиантай орчинд ажиллаж буй ажиллагсдыг чихэвч болон бусад хамгаалах хэрэгслээр хангах	Гурилын тээрмийн хэсэг	Ширхэг	10.0	40	400.0	Жилд 1 удаа	MNS 6768:2019 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага
3	Төслийн талбайд ажиллаж буй тээврийн хэрэгслийн дотоод шаталтын хөдөлгүүрээс стандарт давсан агаар	Үйлдвэрийн тээврийн хэрэгслүүдийг авто тээврийн үзлэг оношилгоонд хамруулах, тэнцээгүй тээврийн хэрэгсэл ашиглахгүй байх	Төсөлд ашиглаж буй тээврийн хэрэгслүүд	Ширхэг	33.0	10	330.0	Төслийн үйл ажиллагааны явцад тогтмол хэрэгжүүлэх	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоо явуулах журам Дугаар А/199

**Дархан-Уул хотын Дархан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй
“Босоо технологит гурилын үйлдвэр” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	бохирдуулагч хий ялгарах								
4	Агаар орчин бохирдох	Аграарын чанарын мониторинг хийх хийх	ОХШХ-т тусгасан						Агаарын тухай хууль
Усан орчин									
5	Усны нөөцийг хэмнэлттэй ашиглах	Усны оролт болон гаралт дээр суурилуулсан тоолуурыг баталгаажуулах	Төвлөрсөн эх үүсвэр	Ширхэг	30.0	3	90.0	2026 он	Ус ашиглах хэрэглээг тоолууржуулах журам, Усны тухай хууль Эрүүл мэндийг хамгаадах. Аюулгүй байдал MNS 0900:2015 Усны чанар. “Газрын доорх усыг бохирдуулагч бодисын ЗДХ” MNS 6148:2010 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага. MNS 4943:2015
6	Ус ашигласны, бохирдуулсны төлбөр төлөх	Ус ашигласны төлбөр төлөх	Тоолуурын заалт	ҮА-ны зардлаар				2026 он	
7		Ус бохирдуулсны төлбөр төлөх	Хаягдал усны дүгнэлт гаргуулах	ҮА-ны зардлаар				2026 он	
8		Бохирдуулагч бодис бүрээр хаягдал усанд шинжилгээ хийх, жишиг үнээр органик бохирдуулагчийг хянах	Хаягдал бохир усыг шинжлүүлэх	мян.төг	200.0	-	200.0	2026 он	
Хөрсөн бүрхэвч									
9	Үйлдвэр орчмын хөрс хүний болон зам, тээврийн үйл ажиллагаанд өртөж, элэгдэл эвдрэлд орох	Ургамлан нөмрөг нь талхлагдаагүй газруудыг хамгаалж, тор татах	Үйлдвэрийн гаднах талбайд	ҮА-ны зардлаар				2026 он	MNS 6260:2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэхүр тарих, арчлах
10	Хог хаягдлыг эмх цэгцгүй хадгалж, хаяснаас орчин бохирдох	Газрын хөрсөн дээр хог хаягдал хаягдахаас сэргийлэх, тогтоосон	Үйлдвэрийн гаднах талбайд	ҮА-ны зардлаар				2026 он	Хог хаягдлын тухай хууль

**Дархан-Уул хотын Дархан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй
“Босоо технологит гурилын үйлдвэр” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

		цэгт хурааж, тогтмол зайлуулах							
11	Орчны тохижилт, ургамалжуулалт хийгдээгүйгээс талхагдал, хуурайшил ажиглагдах	Үйлдвэрийн талбайд ногоон байгууламж хийж гүйцэтгэх	Үйлдвэрийн талбайд	мян.төг	300.0	м ²	300.0	2026 он	MNS 6260:2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх үр тарих, арчлах
НИЙТ ЗАРДАЛ							1,320.0 мян.төг		

4.2. Ажиллагсдын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны төлөвлөгөө

Хүснэгт 3. Ажиллагсдын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны зааварчилгаа зөрчсөнөөс хүний эрүүл мэнд, амь насанд аюул учрах	Үйлдвэрийн ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Үйлдвэрийн ажилчид	200.0	200.0	2026 он	MNS 5566:2005 Гал түймрээс хамгаалах. Аж ахуйн нэгж, Байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм. MNS(ISO) 13688:2000 Хөдөлмөр хамгааллын хэрэгсэлд тавигдах шаардлага
2		Ажиллагсдын байранд эмийн сан байршуулах, анхны тусламж үзүүлэх	Үйлдвэр болон оффист	50.0	100.0		
3		Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	“Улаанбаатар гурил” 152 ажилчид	Дотоод төлөвлөлтөөр			
4		Үйлдвэрт галын хор, гал унтраах иж бүрэн хэрэгслээр хангаж ажиллах	Оффис, гурилын үйлдвэр, агуулах	200.0	400.0		
5		Үйлдвэрийн аюултай хэсгүүдэд сэрэмжлүүлэх тэмдэг тэмдэглэгээ дохио үгийг байршуулах, нүдэнд харагдахуйц тод байрлуулна	Тээрэм, гурил савлах, хивэг савлах, буудай буулгах, цахилгааны шитүүд гэх мэт	50.0			
6	Шавж устгал хийх, шавж, жоом, шоргоолж, бясаны эсрэг	Улиралд нэг удаа шавж устгал хийх	Гурилын үйлдвэр, агуулах, буудайн агуулах	500.0		Улиралд 1 удаа	

**Дархан-Уул хотын Дархан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй
“Босоо технологит гурилын үйлдвэр” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

7	Бохирдох, үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Ган торх дүүргэгч төхөөрөмжүүдийг дамжлагуудын гадна талыг хөөсрүүлж халдваргүйжүүлэх	Буудайн агуулах	400.0		
7				1650.0 мян.төг		

4.3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гал түймэр, үер, хүчтэй аадар, цасан шуурга зэрэг байгалийн давагдашгүй хүчин зүйлд өртөх	Давагдашгүй хүчин зүйлийн үед хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байх, сургалт хий	Үйлдвэрийн ажиллагсад	1	300.0	300.0	2026 он	Гамшгаас хамгаалах тухай хууль
2	Гал гарах, үйлдвэр болон хүрээлэн буй орчинд гал тархах	Галын хорын булан, галын хор байрлуулах	Үйлдвэр агуулах болон бусад газруудад	1	130.0	130.0	2026 он	Ерөнхий шаардлага MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй
3	Ажлын байрны хөдөлмөр, эрүүл ахуйн нөхцөлийг хангаагүйгээс ажиллагсдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Хөдөлмөр хамгааллын зөвлөмжийг хэрэгжүүлэх	Үйлдвэрийн ажиллагсад	2	ҮА-ны зардал		2026 он	Ерөнхий шаардлага MNS 4996:2000 Ажлын байрны гэрэлтүүлгийн норм
НИЙТ ЗАРДАЛ					430.0 мян.төг			

4.4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 5. Тарималжуулах ажилд зарцуулах зардлын хэмжээ

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Шаардагдах хэмжээ	Зардал мян.төг
1	Шар хуайс	ш	100	250.0
2	Хайлаас	ш	100	200.0
5	Ногоон байгууламж хийх, цементэлсэн талбайд цэцгийн мандал байгуулах	м ²	100	50.0
НИЙТ ЗАРДАЛ			500.0 мян.төг	

1 га-д шаардлагатай модны тоо ширхгийг тооцоолохдоо эгнээ хоорондын зай (2м), мод хоорондын зай (1.5-2.0) суулгацын диаметр зэргийг тооцоолон бодоход ойролцоогоор жилд 200 ширхэг суулгац шаардлагатай. Уг төслийн хүрээнд 200 ширхэг орчим суулгац тариалан, ургамалжуулах буюу мод, бут тариалах шаардлагатай.

4.5. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн

Монгол улмын ерөнхийлөгч НҮБ-ийн ерөнхий Ассемблейн 76-р чуулган дээр байгаль орчны доройтол, цөлжилт, шар шороон шуургатай тэмцэх зорилгоор Монгол улс 2030 он гэхэд нэг тэрбум мод тарьж ургуулахаа зарласан “Улаанбаатар гурил” ХХК нь Дархан-Уул аймгийн Дархан суманд байрлах “Mon Beef” махны үйлдвэрийн талбайд 200 ширхэг мод тарина.

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	Авах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн	Мод тарих	-	Ширхэг	200	2.0	400.0	2026 он	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

4.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд газрын тос, уул уурхай,цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт зэрэг төсөлд хаалтын үйл ажиллагааны чиглэл, нөхөн сэргээлтийн зорилт, хамрах хүрээ гэсэн шалгуурууд дүйцүүлэн хамгааллын арга хэмжээнд төлөвлөнө гэж заасан байдаг (*Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ 8.4.6*). Тиймээс дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага гарахгүй болно.

4.6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ

“Улаанбаатар гурил” ХХК-ийн үйл ажиллагаа нь Дархан-уул аймгийн Дархан сумын 13-р баг, үйлдвэрийн районд үйл ажиллагаа, үйлдвэрлэл явуулдаг тул нүүлгэн шилжүүлэлт хийгдэхгүй.

4.7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй. Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн Хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” хэмээн заасны дагуу

**Дархан-Уул хотын Дархан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй
“Босоо технологит гурилын үйлдвэр” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлага мөрдөн ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь төслийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны яамны тусгай зөвшөөрөлгүйгээр зааж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

4.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын тухай хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, хүрээлэн буй орчныг цэвэрлэх, устгах харилцааг зохицуулахад оршино.

Хүснэгт 6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдал болон бие засах газрын хаягдлаар ус, хөрс бохирдох	Хог хаягдлыг тухай бүрд нь зайлуулах	Удаа	Байгууллага хоорондын гэрээгээр			2026 он	Хог хаягдлын тухай хууль MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал, ерөнхий шаардлага
2	Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулаагүйгээс агаар, хөрс, усыг бохирдуулах сөрөг нөлөөлөл учруулах	Хог хаягдлын тусгайлсан цэгт орчны бохирдлыг үүсгэхгүй байх нөхцөлийг хангасан зориулалтын хайрцаг савны битүүмжлэлийг хангах	Тогтмол				2026 он	
3	Хог ил задгай хаях	Хогийн түр сав байршуулах	ш	100.0	2	200.0	2026 он	
4	Хог хаягдлыг ангилаан ялгах	Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулах, дахин ашиглах боломжтой зүйлс (цаас, шил, хуванцар сав, хаягдал дугуй г.м)-ийг шаардлагатай газруудад нийлүүлэх	-	-	-		2026 он	
5	Хог хаягдлыг удаан хугацаагаар зориулалтын бус газарт хадгалснаар ялзарч муудах, халдварт өвчин тархах нөхцөл бүрдэх	Тухай бүр зайлуулах	-	-	-		2026 он	
НИЙТ ЗАРДАЛ				200.0 мян.төг				

4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тухайн төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн байгаа орчны бүрэлдэхүүн хэсэг (агаар, хөрс, усан орчин)-т сөрөг нөлөөлөл, өөрчлөлтийг үзүүлж байгаа эсэхэд хяналт тавих, бохирдлыг хянах боломж бүрдэнэ.

Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Зардал, мян.төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
1.	Хүхэрлэг хий (SO ₂)	Үйлдвэрийн орчим болон авто зогсоол	1	1	150.0	MNS 4585:2025
2.	Азотын давхар исэл (NO ₂)					
3.	PM _{2.5} , PM ₁₀					
4.	Дуу чимээ					
5.	Хөрсний хүнд металлын үзүүлэлт	Машины зогсоол, агуулахын ачиж буулгах хэсэг	1	1	50.0	MNS 5850:2019
6.	Хөрсний физик химийн шинж чанар	Ногоон байгууламж,	1	1	50.0	MNS 3297:2019
7.	Ундны усны чанарын үзүүлэлт	Унд ахуйн ус	1	1	50.0	MNS 0900:2018
8	Бохир ус	Хаягдал ус	1	1	100.0	MNS 6561:2015
НИЙТ ЗАРДАЛ					400.0 мян.төг	

4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага

Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			X	XI	XII		
1	Жил бүрийн БОМТ-г Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүргүүлж батлуулах	ҮА-ны зардал			+	ХАБЭА-н алба	Тухайн жилийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоно.
2	Жил бүрийн БОМТ-ний биелэлтийн тайланг Дархан-Уул аймгийн Байгаль орчин аялал жуучлалын газар хүргүүлж, дүгнүүлэх, тайлагнах	ҮА-ны зардал		+		ХАБЭА-н алба	Албан бичгээр хүргүүлэх
3	Байгаль орчны хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль орчны дотоод хяналтыг хэрэгжүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулж, бууруулж ажиллах	ҮА-ны зардал	+	+	+	Дотоод хяналтын алба	Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам .

**Дархан-Уул хотын Дархан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй
“Босоо технологит гурилын үйлдвэр” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

4	Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын тухай хууль, журам, стандартын биелэлтийг хангах зорилгоор дотоод хяналтыг зохион байгуулах	ҮА-ны зардал	+			Дотоод хяналтын алба	Шалгалтын үр дүнг илтгэсэн тайлангаар биелүүлэх.
НИЙТ ЗАРДАЛ				ДОТООД ЗАРДЛААР			

4.11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ багийн ИНХ, сумын захиргааны байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх байдлаар хэрэгжүүлж болно.

Хүснэгт 9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан
1	Дархан-Уул аймгийн Байгаль орчны газар	Цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргүүлнэ.	2026 оны БОМТ-ний биелэлт	Тухайн жилийн 10-р сард багтаан хэрэгжүүлнэ.	ҮА-ны зардал	Компанийн Удирдлага, ХАБЭА-н ажилтан, Зөвлөн гүйцэтгэгч
2	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргүүлнэ.	2027 оны БОМТ-ний төлөвлөгөө	Тухайн жилийн 12 сард багтаан хэрэгжүүлнэ.	ҮА-ны зардал	Компанийн Удирдлага, ХАБЭА-н ажилтан, Зөвлөн гүйцэтгэгч

Төслийн 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардлыг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гүйцэтгэх хугацаа	Нийт дүн
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	төг	2026 он	1,320.0
2.	Ажиллагсдын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны төлөвлөгөө	төг		1,650.0
3.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	төг		430.0
4.	Тарималжуулах ажилд зарцуулах зардлын хэмжээ	төг		500.0
5.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн	төг		400.0
6.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	төг		300.0
7.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	төг		400.0
НИЙТ ДҮН			5,000.0 мян.төг	

"УЛААНБААТАР ГУРИЛ" ХХК НИЙ ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
НУТАГТ ХЭРЭГЖИНЭ. НУТАГТ ОРШИХ "БОСОО ТЕХНОЛОГИТ ГУРИЛЫН
ҮЙЛДВЭР" ТӨСӨЛ ТӨСЛИЙН 2025ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2624036



ХЯНАСАН:

ХБОБХГ-ЫН ШИНЖЭЭЧ

З. АЗЖАРГАЛ

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

"УЛААНБААТАР ГУРИЛ"

ХХК-ИЙН ЗАХИРАЛ

"УЛААНБААТАР ГУРИЛ"

ХХК-ИЙН БАЙГАЛЬ

ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Б.СОЁЛМАА

С.ЛУВСАНДАГВА

2025 ОН